



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 27 өдөр

Дугаар А/197

Мандалговь

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "а", Боловсролын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2,3 дахь хэсэг Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын ЕБСургуулиудын сурагчдад эх оронч хүмүүжил олгох, дэлхийн болон Монгол улсын гүн ухаантнуудаас суралцах, хувь хүнийг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлж, хөрөнгө зарцуулсугай.

2. Ном худалдан авахад шаардагдах 150000 (Нэг зуун тавин мянган) төгрөгийг Засаг даргын нөөцийн зардлаас гаргахыг Тамгын газрын дарга (Б.Оюунчимэг), ня-бо (О.Бямбасүрэн) нарт зөвшөөрсүгэй.

3. Номыг ЕБСургуулиудад олгож, баримт бүрдүүлэхийг Тамгын газрын дарга (Б.Оюунчимэг), Нийгмийн бодлогын мэргэжилтэн (О.Уранзаяа) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Р.МӨНХТОГТОХ